




Батлав:  С. Ламбаа
ЭМСЯ-ны Төрийн нарийн бичгийн
дарга, Эмнэлгийн мэргэжилтний
хөгжлийн зөвлөлийн дарга




Зөвшөөрсөн:  Р. Сандуйжав
ЭМСЯ-ны Хавдрын судлалын мэргэжлийн
салбар зөвлөлийн дарга



**“ХАВДРЫН ХӨНГӨВЧЛӨХ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР
МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ”**

Боловсруулсан:  Ц. Гантуяа / ХСҮТ-ийн Хөнгөвчлөх эмчилгээний сургалт арга
зүйн тасгийн эрхлэгч /

Хянасан:  Г. Пүрэвсүрэн / ХСҮТ-ийн эрдэм шинжилгээ сургалт,
мэдээлэл эрхэлсэн дэд захирал, АУ-ны доктор /

Улаанбаатар хот
2016 он

1.1 Мэргэжлийн тодорхойлолт: Хавдрын хөнгөвчлөх эмчилгээний эмч нь өрх сумын эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түвшинд хорт хавдартай өвчтөний өвдөлт, биеийн бусад шаналгаат шинжүүд, сэтгэлийн шаналгаа, түүний гэр бүлд байгаа нийгэм-сэтгэцийн бэрхшээлийг үнэлж, зохих эмчилгээ, тусламж үйлчилгээ үзүүлэх мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн, шаардлагатай үед нарийн мэргэжлийн тусламжид шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх, бусад мэргэжлийн эмч нарт мэргэжлийн зөвлөгөө өгөх чадвартай эмч байна.

1.2 Мэргэжлийн чиглэл: Хавдрын хөнгөвчлөх эмчилгээ судлал

1.3 Мэргэжлийн индекс:

1.4 Сургалтын хэлбэр: Өдрийн хэлбэр

1.5 Сургалтын хугацаа: 5 сар

1.6 Сургалтын багтаамж: 20 багц цаг

1.7 Элсэгчдийн боловсролын түвшин: ЭМШУИС, Анагаах Ухааны Дээд Сургуулийн анагаахын салбарыг бакалаврын зэрэгтэй төгссөн, хүний их эмчийн дипломтой, Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эрүүл мэндийн салбарт хоёр ба түүнээс жил ажилласан эмчийг шалгаж элсүүлнэ.

1.8 Олгох мэргэшлийн нэршил: Хавдрын хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр дээшлүүлэх

1.9 Сургалтын түвшин: Төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалт

1.10 Сургалтын төлөвлөгөө

д/д	Хичээлийн нэр	Онол	Семинар	Дадлага	Хугацаа
1.	Хавдрын үеийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээний ерөнхий ойлголт	3	12	12	1долоо хоног
2.	Цочмог, архаг, шаналгаат өвдөлтийн менежмент	3	12	12	1долоо хоног
3.	Хөнгөвчлөх мэс засал эмчилгээ	3	12	12	1долоо хоног
4.	Мэс засал эмчилгээний дараах хөнгөвчлөх эмчилгээ	3	12	12	1долоо хоног
5.	Хөнгөвчлөх хими эмчилгээ	3	12	12	2долоо хоног
6.	Хими эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3	12	12	1долоо хоног
7.	Хөнгөвчлөх туяа эмчилгээ	3	12	12	1долоо хоног
8.	Туяа эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3	12	12	1долоо хоног
9.	Хөнгөвчлөх туяа эмчилгээ	3	12	12	1долоо хоног
10.	Туяа эмчилгээний үеийн хөнгөвчлөх	3	12	12	1долоо

	ЭМЧИЛГЭЭ				ХОНОГ
11.	Хоол эмчилгээ	3	12	12	2долоо хоног
12.	Өвчний тавилан, муу мэдээ хүргэх, нас барах үеийн болон барсны дараах тусламж	3	12	12	1долоо хоног
13.	Хөнгөвчлөх эмчилгээний үеийн тусламж, зайлшгүй шаардлагатай гардан үйлдэл	3	12	12	2долоо хоног
14.	Өвдөлт намдаах эмийн тухай	3	12	12	2долоо хоног
15.	Хүн амын дунд сургалт, сурталчилгаа явуулах	3	12	12	1долоо хоног
16.	Хүнд хэвтрийн болон стомитой өвчтөний сувилгаа	3	12	12	1долоо хоног
	Нийт цаг	48 цаг	192 цаг	192 цаг	20 долоо хоног
	Эзлэх хувь	20%	40%	40%	100%
	Нийт багц цаг	4 кр	8 кр	8 кр	20 кр

1.1 Хөтөлбөрийн үндэслэл:

Дэлхий дахинаа жилд 12.7 сая хүн хорт хавдраар шинээр өвчилж, 7.6 сая хүн хорт хавдрын улмаас нас барж байна. ДЭМБ-ын тооцоолж байгаагаар хэрэв хорт хавдраас сэргийлэх оновчтой, үр дүнтэй арга хэмжээ цаг алдалгүй авч хэрэгжүүлэхгүй бол 2030 он гэхэд жил бүр 26.0 сая хүн хорт хавдраар шинээр өвчилж, 17.0 сая хүн хорт хавдраар нас барах магадлалтай байна. Манай орны хувьд ч хорт хавдрын өвчлөл жилээс жилд өсөх хандлагатай байна. Жилд 4500 гаруй хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдэж, хорт хавдар өвчин нь хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болж байгаа төдийгүй улс орны нийгэм, эдийн засагт ихээхэн дарамт учруулж байна.

Хорт хавдрын шинэ тохиолдлын 75 гаруй хувь нь хожуу үе шатандаа оношлогдож байна. Жилд 3272 хүн хорт хавдрын улмаас нас барж байгаагийн 2151 (65,7%) нь анх оношлогдсон тухайн жилдээ нас барж байна (2011 оны статистикийн мэдээ). Хавдар судлалын үндэсний төвийн хөнгөвчлөх эмчилгээний тасагт 2003 онд 511 хүн хэвтэн эмчлүүж байсан бол 2011 онд 724 хүн хэвтэн эмчлүүлж 229 хүн нас барсан. Ийнхүү хөнгөвчлөх эмчилгээ шаардлагатай өвчтний тоо жилээс жилд өсөж байгаатай холбоотой хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, мэргэжилтний хэрэгцээ шаардлага мөн нэмэгдэж байна.

Монгол улсын Засгийн газрын 2005 оны 246 тоот тогтоолоор батлагдсан Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй Хорт хавдар өвчнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Эрүүл мэндийн сайдын 292 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор эмчлэх боломжгүй хожуу үедээ илэрсэн хавдартай хүмүүст үзүүлэх хөнгөвчлөх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгыг хангахын тулд аймаг, дүүргийн эмч, сувилагч нарт хөнгөвчлөх эмчилгээний сургалт зохион байгуулах, үндэсний сургагч багш нарыг бэлтгэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

1.2 Хөтөлбөрийн зорилго:

Эмчилгээ хийх эрх бүхий ерөнхий мэргэжлийн ба нарийн мэргэжлийн эмч нарт өвчин нь хурдан даамжирч, илаарших боломжгүй болсон тавилан муутай өвчтний сэтгэлийн шаналгаа, өвдөлт, биеийн бусад шаналгаат шинжүүд, түүний гэр бүлд байгаа нийгэм-сэтгэцийн бэрхшээлийг үнэлж, сэтгэлийн ба биеийн шаналгааг хөнгөвчлөх болон хавдрын өвөрмөц эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээний мэдлэг, чадвар, хандлага эзэмшүүлэх

1.3 Хөтөлбөрийн зорилт:

- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний үндсэн зарчмын талаар ойлголт олгох, дадал, чадвар эзэмшүүлэх

- Хавдрын цочмог, архаг өвдөлтийн менежментийг судлуулж, мэдлэг эзэмшүүлэх
- Хавдрын үеийн шаналгаат шинжийн менежментийг судлуулж, мэдлэг эзэмшүүлэх
- Хавдрын хөнгөвчлөх мэс засал ба мэс засал эмчилгээний дараах хөнгөвчлөх эмчилгээний талаар мэдлэг эзэмшүүлэх
- Хавдрын өвөрмөц эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ: хими эмчилгээ, туяа эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээний талаар мэдлэг олгох, дадлагажуулах
- Хөнгөвчлөх эмчилгээнд сувилахуйн тусламж: зонхилон тохиолдох хавдар болох элэг, ходоод, улаан хоолой, уушиг, умайн хүзүүний хавдрын талаар мэдлэг олгох, дадлагажуулах
- Хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээний ерөнхий зарчмын талаар судлуулж, мэдлэг эзэмшүүлэх

1.4 Зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг:

1. Хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээний талаар
 - Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний үндсэн ойлголт, зарчим, төрөл
 - Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний талаар хууль, тогтоомж, стандарт, эмнэл зүйн удирдамж, тушаал заавар, эрх зүйн баримт
 - Хөнгөвчлөх тусламжинд хамруулах шалгуур
 - Хөнгөвчлөх тусламжийн үнэлгээ, хяналт, бүртгэл, мэдээлэл
 - Хөнгөвчлөх тусламжийн шуурхай байдал
2. Хавдрын цочмог, архаг өвдөлтийн менежмент
 - Цочмог өвдөлтийн менежмент
 - Архаг өвдөлтийн менежмент
 - Ажилбарын аргаар өвдөлт намдаах арга
 - Өвдөлт намдаах уламжлалт эмчилгээний арга
 - Өвдөлт намдаах эмийн бус арга
3. Хавдрын үеийн шаналгаат шинжийн менежмент
 - Дотор муухайрах, бөөлжих, хоолонд дургуй болох шинжийн менежмент
 - Амьсгаадах, ханиалгах шинжийн менежмент
 - Тураалын менежмент
 - Өтгөн хаталтын менежмент
 - Түгжрэлийн менежмент
 - Асцитын менежмент
 - Дэмийрлийн менежмент
 - Сэтгэл гутралын менежмент
 - Суулгалтын менежмент

- Ядрах тамирдахын менежмент
 - Нойргүйдлийн менежмент
 - Загатнах шинжийн менежмент
4. Хавдрын хөнгөвчлөх бусад тусламж үйлчилгээний талаар
- Хавдартай өвчтөн ба түүний асран хамгаалагчид үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ
 - Хавдартай өвчтөн ба түүний асран хамгаалагчид үзүүлэх нийгмийн тусламж үйлчилгээ (гэрээслэлийн тухай)
 - Хавдартай өвчтөнд үзүүлэх хоол зүйн тусламж үйлчилгээ
 - Хөнгөвчлөх яаралтай тусламж (цус алдах, амьсгал боогдох, яс хугарах, түгжрэл болох, тархины хаван, дээд хөндий вен дарагдах, гэдэс цоорох)
 - Нас барах үеийн тусламж үйлчилгээ
 - Өвчний тавилан тодорхойлох, муу мэдээ хүргэх, нас барсны дараах тусламж үйлчилгээ
 - Хөнгөвчлөх эмчилгээнд хэрэглэх эмийн тухай
5. Бусад
- Хөнгөвчлөх мэс засал ба мэс засал эмчилгээний дараах хөнгөвчлөх эмчилгээ
 - Хөнгөвчлөх хими эмчилгээ ба хими эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ
 - Хөнгөвчлөх туяа эмчилгээ ба туяа эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ
 - Хавдрын өвөрмөц эмчилгээ дуусаад хяналтанд байх үеийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ
 - Хөнгөвчлөх эмчилгээний үеийн сувилахуйн тусламж (элэг, ходоод, улаан хоолой, уушиг, умайх хүзүүний хавдар)
 - Зонхилон тохиолддог хавдрын үеийн хөнгөвчлөх эмчилгээний онцлог

1.5 Зайлшгүй эзэмшвэл зохих чадвар:

- Хавдартай өвчтнийг үзэх, үнэлэх, хөнгөвчлөх тусламжинд хамруулах, хянах, тусламж үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах чадвар
- Хавдартай өвчтний өвдөлт болон шаналгаат шинжийг үнэлэх, эмчлэх, хянах, энэ талаар өвчтөн ба түүний асран хамгаалагч нарт зөвлөгөө өгөх чадвар
- Хавдартай өвчтөн, түүний гэр бүлийнхэнд сэтгэл зүйн үнэлгээ өгөх, сэтгэл зүйн тусламж үзүүлэх арга барил
- Хавдартай өвчтөн, түүний гэр бүлийнхэнд нийгмийн байдалд үнэлгээ өгөх, нийгмийн тусламжийн талаар зөвлөгөө өгөх арга барил

- Хавдартай өвчтөн, түүний гэр бүлийнхэнд хоолны зөвлөгөө өгөх арга барил
- Хавдартай өвчтөн түүний гэр бүлийнхэнд муу мэдээ хүргэх, үнэн зөв мэдээлэл өгөх, тавилан ойлгуулах чадвар
- Зайлшгүй шаардлагатай гардан үйлдэл (хэвлий болон цээжний хөндийн хатгалт, давсагны хатгалт, ходоодны зонд тавих, хамрын хөндий, үтрээнд чихээс тавих, захын хаванд урсгуур тавих, дуслын шахуурга ажиллуулж сурах)
- Төрөл бүрийн шалтгаант шарх цэгцлэх (хавдар, холголт цооролт, мэс заслын дараах, туяа эмчилгээний түлэгдэлийн шарх, үрэвслийн шалтгаант)
- Стоми ба гуурсны арчилгаа (гастростоми, илеостоми, колостоми, трахеостоми, цөс гадагшлуулах гуурс, хэвлий, цээж, зүрхний гялтангийн хөндийд тависан гуурс, эпидурал, төвийн венийн гуурс арчлах)
- Хэвтрийн өвчтний сувилгаа, зөвөлгөө (байрлал солих, ивээс хийх, бие засуулах, хооллох, эм өгөх) өгөх
- Судсаар хооллох арга барил
- Шарил цэгцлэх, зөөвөрлөх, илгээх чавдар
- Хүн амын дунд сургалт, сурталчилгаа явуулах чадвар
- Багаар ажиллах чадвар
- Мэргэжлийн ном хэвлэл, интернетээс мэдээлэл олж авах, практикт хэрэглэх

1.6 Зайлшгүй эзэмшвэл зохих хандлага:

- Монгол улсын хууль тогтоомж, эрүүл мэндийн салбарын эрх зүйн орчинд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлэх
- Хавдрын ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах хандлагатай болох
- Өвчтний эрүүл мэндийн байдал, нас, хүйс, боловсрол, шашин, эдийн засгийн боломж, нийгэм, гэр бүлд эзлэх байр суурийг үл харгалзан хүнлэг энэрэнгүй хандан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх
- Өвчтөн түүний гэр бүлээс үүсэх алив маргаантай асуудлыг тал бүрээс нягтлах хүлээцтэй хандах
- Өвчтөн өөрийгөө хянах чадвар сул, шийдвэр гаргах үйл ажиллагаа буурсан байдлыг гэр бүлийн гишүүдэд ойлгуулах дэмжлэг үзүүлэх
- Үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа хорт хавдрын урьдчилан сэргийлэх, хянах хөтөлбөр тушаал шийдвэрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох
- Өвчтний нууцлалыг хадгалах, нэр хүндийг өргөх, санал бодлыг харгалзан үзэх хандлага

1.7 Сургалтын залгамж холбоо:

Босоо тэнхлэгээр:

- Өрхийн эмч
- Сумын эмч
- Хавдар судлаач эмч
- Туяаны эмч
- Химийн эмч
- Хавдрын мэс заслын эмч
- Бусад нарийн мэргэжлийн эмч

Хэвтээ тэнхлэгээр:

- Клиник фармакологи
- Клиник сэтгэл зүй
- НЭМ , судалгааны арга барил
- Гадаад хэл
- Компьютер

1.8 Сургалт явагдах газар: Хавдар судлалын үндэсний төв

1.9 Хөтөлбөрийн агуулга: 20 багц цаг

1. **Хөнгөвчлөх тусламжинд хамруулах шалгуур:** Өвчтөний амьдралын үлдсэн хугацаанд хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хэрхэн нөлөөлөхөд онцгой анхаарна. Ингэхийн тулд дараах гурван бүлэг хүмүүст хөнгөвчлөх тусламжийг хэрхэн яаж хүргэж болохыг тодорхойлно: (1) амьдрах хугацаа хэдэн сараас нэг жил хүртэл (2) амьдрах хугацаа хэдэн сараас хэдэн долоо хоног хүртэл (3) эсвэл амьд байх боломж хэдэн долоо хоног хэд хоног үлдсэн. [ECOG]-ийн оноо (Eastern Cancer Oncology Group) 3 буюу түүнээс их; Карнофски оноо 50 буюу түүнээс бага, гиперкальцеми, эд эрхтэнд хавдар үсэрхийлсэн, дээд хөндий венийн хам шинж, нугас дарагдах хам шинж, кахекси, элэгний дутмагшил, бөөрний дутмагшил, бусад ноцтой хавсарсан өвчин, өвчтөн буюу түүний ар гэрийнхний зүгээс хөнгөвчлөх эмчилгээ хийлгэх хүсэл гаргах нь шийдвэр гаргахад харгалзах нэг хүчин зүйл юм.
2. **Хөнгөвчлөх тусламжийн үнэлгээ:** Хавдрын эсрэг эмчилгээний үр дүн ба эрсдлийг үнэлэх, хавдар эхэлж даамжирсан эмгэг жам, цаашдын эмчилгээнд үр дүн гарах магадлал, өвчтний амин эрхтний үйл ажиллагааны болон

биеийн ерөнхий байдал, хавсарсан ноцтой эмгэг байгаа эсэх, Биеийн ба нийгэм-сэтгэцийн шинж байгаа эсэхийг үнэлэхдээ өвдөлт, амьсгалах үйл ажиллагааны алдагдал, тураал, шингэн дутагдал, ходоод гэдэсний хямрал, тамирдалт, унтаа байдал, нойргүйдэл, дэмийрэл, сэтгэл гутрал, түгшил, бусад нийгэм-сэтгэцийн, сэтгэл зүйн шаналал зэрэгт үнэлгээ өгнө. Өвчтний хувийн, мөн сэтгэл зүйн хүлээлт, санаж бодож байгаа асуудал, нийгмийн дэмжлэг бусад асуудал; өвчтөн ба гэр бүлийнхнээс юуг хүсч байгаа, зайлшгүй шаардлагатай байгаа хөнгөвчлөх тусламж, хавдрын эсрэг эмчилгээний зорилго, оюун санаа, шашин гэх мэт зүйлсийг асууж судлах

3. **Хөнгөвчлөх тусламжийн цогц үйлчилгээг эрт үзүүлэх шалгуур:** Нийгмийн талаас зохих дэмжлэг авч чадахгүй байгаа, санхүүгийн боломжгүй, тусламж үйлчилгээг хүртээмжтэй авч чаддаггүй, тусламж үзүүлэгч нь хангалтгүй, гэр бүлийн зөрчилтэй, гэр бүлд нялх балчир хүүхэдтэй байх зэрэг нь хөнгөвчлөх тусламжийн цогц үйлчилгээг эрт эхлэх шаардлагатайг тодорхойлох нийгмийн хүчин зүйлс юм.
4. **Хавдартай өвчтөний өвдөлтийн менежмент:** Өвчтөнийг өвдөх зовиур шаналгаагүй байлгах, өвдөлт намдаах эмчилгээг “Хөнгөвчлөх эмчилгээ өвдөлт намдаах эмчилгээний эмнэл зүйн удирдамж”-ийн дагуу эмчлэх
5. **Хавдартай өвчтөнд гарах шаналгаа зовиурыг эмчлэх:** (дотор муухайрах, бөөлжих, амьсгаадах, ханиалгах, өтгөн хатах, дэмийрэх, турж эцэх, тамирдах, суулгах, нойргүйдэх г.м)
6. **Яаралтай тусламж үзүүлэх:** Цус алдах, амьсгал боогдох, яс хугарах, түгжрэл болох, тархины хаван, дээд хөндий вен дарагдах, гэдэс цоорох зэргийн тусламж үзүүлэх
7. **Хөнгөвчлөх мэс засал, туяа, хими эмчилгээ:** Хавдрын эсрэг эмчилгээний үр дүн ба эрсдлийг үнэлэх, эмчилгээнд оруулах, өвөрмөц эмчилгээний явцад гарах хүндрэлүүдийн хөнгөвчлөх эмчлэх
8. **Хавдартай өвчтөнд сэтгэл зүйн, нийгмийн тусламж үзүүлэх:** Сэтгэл зүйн болон нийгмийн байдалд үнэлгээ өгөх, харилцах ярилцах чавдар, амьдралын утга учир, гэрээслэлийн ач холбогдол, үнэн зөв мэдээлэл хүргэх, тавилан тодорхойлох, муу мэдээ хүргэх, сэтгэл зүйн, нийгмийн талын зөвлөгөө өгөх

1.10 Зайлшгүй суралцах бие даалтын сэдэв

- Хүүхдийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ
- Өндөр настны хөнгөвчлөх туламж үйлчилгээ
- Хавдрын бус өвчтэй өвчтний хөнгөвчлөх тусламж үйлчилгээ
- Хар тамхичин (Наркоман) өвчтний өвдөлт намдаах эмчилгээ

Лекцийн хичээлийн төлөвлөгөө

д/д	Хичээлийн нэр	Онол
1.	Хавдрын үеийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээний ерөнхий ойлголт	3
2.	Цочмог, архаг, шаналгаат өвдөлтийн менежмент	3
3.	Хөнгөвчлөх мэс засал эмчилгээ	3
4.	Мэс засал эмчилгээний дараах хөнгөвчлөх эмчилгээ	3
5.	Хөнгөвчлөх хими эмчилгээ	3
6.	Хими эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3
7.	Хөнгөвчлөх туяа эмчилгээ	3
8.	Туяа эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3
9.	Хөнгөвчлөх туяа эмчилгээ	3
10.	Туяа эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3
11.	Хоол эмчилгээ	3
12.	Өвчний тавилан, муу мэдээ хүргэх, нас барах үеийн болон барсны дараах тусламж	3
13.	Хөнгөвчлөх эмчилгээний үеийн тусламж, зайлшгүй шаардлагатай гардан үйлдэл	3
14.	Өвдөлт намдаах эмийн тухай	3
15.	Хүн амын дунд сургалт, сурталчилгаа явуулах	3
16.	Хүнд хэвтрийн болон стомитой өвчтөний эмчилгээ сувилгаа	3
	Нийт цаг	48 цаг
	Эзлэх хувь	20%
	Нийт багц цаг	4 кр

д/д	Хичээлийн нэр	Онол	Семинар
1.	Хавдрын үеийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээний ерөнхий ойлголт	3	12
2.	Цочмог, архаг, шаналгаат өвдөлтийн менежмент	3	12
3.	Хөнгөвчлөх мэс засал эмчилгээ	3	12
4.	Мэс засал эмчилгээний дараах хөнгөвчлөх эмчилгээ	3	12
5.	Хөнгөвчлөх хими эмчилгээ	3	12
6.	Хими эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3	12

7.	Хөнгөвчлөх туяа эмчилгээ	3	12
8.	Туяа эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3	12
9.	Хөнгөвчлөх туяа эмчилгээ	3	12
10.	Туяа эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3	12
11.	Хоол эмчилгээ	3	12
12.	Өвчний тавилан, муу мэдээ хүргэх, нас барах үеийн болон барсны дараах тусламж	3	12
13.	Хөнгөвчлөх эмчилгээний үеийн тусламж, зайлшгүй шаардлагатай гардан үйлдэл	3	12
14.	Өвдөлт намдаах эмийн тухай	3	12
15.	Хүн амын дунд сургалт, сурталчилгаа явуулах	3	12
16.	Хүнд хэвтрийн болон стомитой өвчтөний сувилгаа	3	12
	Нийт цаг	48 цаг	192 цаг
	Эзлэх хувь	20%	40%
	Нийт багц цаг	4 кр	8 кр

Семинарын хичээлийн төлөвлөгөө

Дадлагын хичээлийн төлөвлөгөө

д/д	Хичээлийн нэр	Онол	Семинар	Дадлага
1.	Хавдрын үеийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээний ерөнхий ойлголт	3	12	12
2.	Цочмог, архаг, шаналгаат өвдөлтийн менежмент	3	12	12
3.	Хөнгөвчлөх мэс засал эмчилгээ	3	12	12
4.	Мэс засал эмчилгээний дараах хөнгөвчлөх эмчилгээ	3	12	12

5.	Хөнгөвчлөх хими эмчилгээ	3	12	12
6.	Хими эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3	12	12
7.	Хөнгөвчлөх туяа эмчилгээ	3	12	12
8.	Туяа эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3	12	12
9.	Хөнгөвчлөх туяа эмчилгээ	3	12	12
10.	Туяа эмчилгээний үеийн хөнгөвчлөх эмчилгээ	3	12	12
11.	Хоол эмчилгээ	3	12	12
12.	Өвчний тавилан, муу мэдээ хүргэх, нас барах үеийн болон барсны дараах тусламж	3	12	12
13.	Хөнгөвчлөх эмчилгээний үеийн тусламж, зайлшгүй шаардлагатай гардан үйлдэл	3	12	12
14.	Өвдөлт намдаах эмийн тухай	3	12	12
15.	Хүн амын дунд сургалт, сурталчилгаа явуулах	3	12	12
16.	Хүнд хэвтрийн болон стомитой өвчтөний сувилгаа	3	12	12
	Нийт цаг	48 цаг	192 цаг	192 цаг
	Эзлэх хувь	20%	40%	40%
	Нийт багц цаг	4 кр	8 кр	8 кр

Гардан үйлдлийн жагсаалт

№	Үйлдлийн нэр	Гүйцэтгэх тоо
1	Хөнгөвчлөх эмчилгээний тасагт жижүүрт гарах	18
2	Хөнгөвчлөх эмчилгээний тасагт өвчтөн үзэх	90
3	Хөнгөвчлөх эмчилгээний өвчтөнд өвдөлтийг үнэлэх, эмчлэх	60
4	Хөнгөвчлөх эмчилгээний өвчтөнд шаналгаат шинжийг үнэлэх, эмчлэх	60
5	Хөнгөвчлөх эмчилгээний өвчтөнд сэтгэл зүйг үнэлэх, зөвлөгөө өгөх	60

6	Хөнгөвчлөх эмчилгээний өвчтөнд нийгмийн байдлыг үнэлэх, зөвлөгөө өгөх	50
7	Хөнгөвчлөх эмчилгээний өвчтөнд хоолны зөвлөгөө өгөх	60
8	Хөнгөвчлөх эмчилгээний өвчтөний тавилан тодорхойлох, муу мэдээ хүргэх, гэр бүлийн уулзалт зохион байгуулах	60
9	Шархны цэгцлэлт хийх	30
10	Хэвлий, цээж, давсагны хатгалт хийх	30
11	Ходоодонд зонд тавих	20
12	Колостоми арчлах, бургуй тавих	20
13	Арьсан дор уян зүү тавих	20
14	Дуслын шахуурга багаж ажиллуулах	40
15	Захын хаванд урсгуур тавих	10
16	Хэвтрийн өвчтний асаргаа хийх	30
17	Уламжлалт эмчилгээний энгийн аргыг сурах	20
18	Нас барахын өмнөх шинжийг тодорхойлох, өвчтөн нас барсны дараа ар гэрийнхэнд муу мэдээ хүргэх	30
19	Шарил цэгцлэх	10
20	Өвчтөн, түүний асран хамгаалагч, олон нийтийн дунд сургалт сурталчилгаа явуулах	10
21	Хэвлэл, мэргэжлийн сэтгүүл, интернэтээс шинэ мэдээлэл олж, орчуулж, сургалтанд ашиглах	10
22	“Уншигч клуб” –ын үйл ажиллагаанд идэвхитэй оролцох, хичээл, лекц бие даан бэлтгэн оролцох	2

1.15 Сургалтын хэрэглэгдэхүүн:

- Сургалтын анги танхим
- Хөнгөвчлөх эмчилгээний тасаг
- Ном сурах бичиг, гарын авлага
- Сургалтын тоног төхөөрөмж
- Интернэтэд холбогдсон компьютер

1.16 Сургалтын арга зүй: Сургалт нь суралцагч төвтэй сургалтын технологит тулгуурлан, бие даан суралцах үйл ажиллагааг дэмжих, чиглүүлэх бололцоо нөхцөлөөр хангахад үндэслэнэ.

- Лекц: Онолын шинэ мэдээлэл, эмнэлзүйн лекц, санал бодлоо харилцан солилцох интерактив лекц гэсэн хэлбэртэй байна.
- Семинар: бага бүлгээр хичээллэн, эмнэлзүйн ховор тохиолдол, оношлох эмчлэхэд түвэгтэй өвчин эмгэгүүдийг асуудал дэвшүүлэн шийдвэрлэх аргаар бүх суралцагчдыг оролцуулна. Энэ асуудлыг суралцагчид өөрсдөө зохион байгуулан хийхийн зэрэгцээ шаардлагатай гэж үзвэл багшийг урин оролцуулах бусад клиникийн эмч нарыг урьж суулган, ном хаялцах болон бусад сонирхолтой хэлбэрээр явуулах болно.
- Бие даалт: багш, тасгийн эрхлэгч, удирдагч эмч нарын удирдлаган дор өвчтөн үзэж, эмнэлзүйн практикт дагалдан ажиллана.
- Сонгон суралцах: Хавдрын тулгамдсан эсвэл өөрийн сонирхсон асуудлаар гүнзгийрүүлэн суралцах боломж нээлттэй байна.
- Дүрд тоглох: Суралцагсад эмч, өвчтний дүрд орж тоглох
- Хүн амын дунд сургалт зохион байгуулах
- Сувилагч нарт сургалт хичээл заах
- Жижиг судалгааны ажил хийх

1.17 Сургалтын үнэлгээ:

- Мэдлэгийн чадвар, хандлагын түвшинг сорил, ярилцлага, эмнэлзүйн тохиолдлын бодлого зэрэг шалгалтын оновчтой хэлбэрийг ашиглан тогтооно.
- Суралцагч нь тасаг нэгж дээр ажиллан, тухайн сэдвээр шүүлэг өгч, хөтөлбөрийн шаардлагыг 80 хувиас дээш хангасан тохиолдолд шалгалтанд орно.
- Суралцагч нь нэг сэдвээр судалгааны ажил хийж, ул үндэстэй дүгнэлт гарган тайлагнаж, зохих кредитийг нэмж авна.
- Төгсөлтийн шалгалтыг онол ба ур чадвар буюу хандлага гэсэн 2 чиглэлээр авах ба онолын шалгалтыг сорил, бодлого, ярилцлага хэлбэрээр, ур чадвар буюу хандлагын шалгалтыг сургалтын явц болон төгсгөлд гардан үйлдэл хийх ур чадвараар нь үнэлнэ.
- Суралцагсдын мэдлэгийг Гэгээрлийн сайдын 1998 оны 255 дугаар тушаалын 1-р хавсралт, ЭМ-ны сайдын 2000 оны 5 сарын 29-ний өдрийн 156 тоот тушаалын 2-р хавсралтыг мөрдөнө.

Үсгэн дүн	Тоон дүн	Процентын дүн
A	4	90-100
B	3	80-89
C	2	70-79
D	1	60-69
F	0	0-59

Энэхүү журмын дагуу үнэлэхэд дараах зарчмыг баримтална.

- Хичээлийн агуулгыг дээд зэрэг ойлгосон , ухагдахуун ойлголтуудыг чадварлаг ашигладаг өргөн мэдлэгтэй бол А гэсэн үнэлгээ
- Хичээлийн агуулгыг сайн ойлгосон , уг хичээлтэй холбоотой тест , логик бодлого бодох, ухагдахууныг ашиглах чадвартай бол В гэсэн үнэлгээ
- Хичээлийн ихэнх хэсгийг хангалттай ойлгосон, хялбар тест, логик бодлого, бодох чадвартай, цаашид энэ чиглэлээр хичээл явуулах хангалттай бэлтгэлтэй бол С гэсэн үнэлгээ
- Хичээлийн ухагдахуунуудыг жигд ойлгоогүй, харьцангуй хялбар тест, бодлого бодох чадвартай боловч зарим алдаа хийсэн бол D гэсэн үнэлгээ
- Хичээлийн агуулгыг муу эзэмшсэн бол F гэсэн үнэлгээгээр үнэлнэ.

А. Явцын үнэлгээ: Сургалт удирдаж буй багш явцын дүнг улирал бүрийн эцэст дараах үзүүлэлтүүдээр дүгнэж гаргана.

№	Үзүүлэлт	%
1	Лекцийн ирц	
2	Дадлага, семинар	
	Жижүүр хийсэн ирц, оролцоо	
3	Бие даалт	
4	Тайлан, шүүлгийн рейтинг	
5	Голч дүн	

Б.Төгсөлтийн шалгалт:

№	Үзүүлэлт	Үсгэн дүн	Тоон дүн	%
Мэдлэгийн үнэлгээ				
1	Сорилын шалгалт			
Гардан үйлдлийн шалгалт				
1	Ур чадвар, хандлага			
2	Гардан ажилбар			

1.18 Заавал ашиглах ном, сурах бичиг, сэтгүүл, вэб сайт:

Вэб сайт:

1. Эрүүл мэндийн яам www.moh.mn
2. ХСҮТ www.cancer-center.gov.mn

3. ДЭМБ www.who.com
4. ЭМГ www.doh.mn
5. АНУ-ын хавдрын үндэсний институт www.cancer.gov
6. МД. Андерсон хавдрын нийгэмлэг www.mdanderson.org
7. www.americanhospice.org
8. www.hospicefoundation.org
9. www.hospicenet.org
10. www.nhpco.org
11. www.caringinfo.org

Номын жагсаалт:

1. Одонтуяа, Д. Орчин үеийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ.2011:Улаанбаатар
2. LL Emanuel, F.F.D., von Gunten Charlz F, Von Roenn J., Хөнгөвчлөх ба амьдралын төгсгөлийн шатны тусламж үйлчилгээний сургалт. Vol. Оролцогчийн гарын авлага. 2006, Улаанбаатар.
3. Мөнхтайван А, Өмөн өвчний төгсгөлийн шатанд нийгмийн зүгээс үзүүлэх дэмжлэг, хөнгөвчлөх эмчилгээ. Суурь сургалтын гарын авлага. 2002: Улаанбаатар р13-15
4. Одонтуяа, Д. Монголд хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хөгжиж буй байдал, Хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үр ашигтай хөгжүүлэх бодлого боловсруулах тухай. 2005: Улаанбаатар. р. 41-51.
5. Д.Одонтуяа, Монгол улсад хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хөгжүүлэх хэрэгцээ ба хөгжиж буй байдал, Хөнгөвчлөх тусламж үйлчилгээг хөгжүүлэх бодлого боловсруулах тухай” бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. 2004. р. 13-18.
6. Одонтуяа, Д. Х. Алтанхуяг, Хөнгөвчлөх эмчилгээний хоспист хэвтэн эмчлүүлсэн өвчтөний судалгаа, Эрдмийн чуулга 52. 2010: Улаанбаатар. р. 115-116.
7. Д. Одонтуяа, Х. Алтанхуяг, Найдвар хоспист хийгдсэн хөнгөвчлөх эмчилгээний судалгаа, Эрдмийн чуулга 51. 2009: Улаанбаатар. р. 43-44.
8. Д.Одонтуяа, Хорт хавдрын үеийн өвдөлтийг намдаах ба хөнгөвчлөх эмчилгээ. 1990, Женев: ДЭМБ.
9. Оюунхүү, Ш. Нас барсны дараах тусламж үйлчилгээ, Хөнгөвчлөх эмчилгээ. 2003: Улаанбаатар
10. Сүхбаатар, Ш. Тунгалагийн хаван, хөнгөвчлөх анагаах ухаан, гүнзгийрүүлсэн сургалтын гарын авлага. 2005: Улаанбаатар
11. Д.Одонтуяа Б.Оргил, Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ. 2003, Улаанбаатар.
12. Одонтуяа, Д. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хөгжиж ирсэн түүх. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хэлбэрүүд, Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, Удирдах ажилтнуудад зориулсан бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. 2002: Улаанбаатар.

13. Хорт хавдрын өвдөлтийг намдаах нь. 2-р хэвлэл. 2005, Женев: ДЭМБ.
14. Өмөнтэй хүүхдийн өвдөлтийг намдаах ба хөнгөвчлөх эмчилгээ. 2002, Улаанбаатар: ДЭМБ, ӨСОУН.
15. Одонтуяа, Д, Хорт хавдрын өвдөлтийг намдаах нь. 2005, Женев: ДЭМБ.
16. Одонтуяа, Д, Дадлагажигч эмчийн сургалтын хөтөлбөр, Архаг өвдөлтийн менежмент. 2009, Улаанбаатар.
17. Одонтуяа, Д. Хөнгөвчлөх эмчилгээний хоспист хэвтэн эмчлүүлсэн өвчтөний судалгаа. Эрүүл Мэндийн шинжлэх ухаан сэтгүүл, 2010.
18. С.Бямбасүрэн, Сэтгэцийн эмгэг судлал. 334-338 ed. 2007.
19. Неврозы, С.А.М. 1982.
20. Лобзин В.С., Р.М.М., Аутогенная тренировка.
21. Д, К.Б., Клиническая психология. 2004. 398-413.
22. Урс Бауманн, М.П., Клиническая психология. 1998.
23. Энхтүвшин.Б, Хүүхдийн өдрийн мэс заслын дараах өвдөлтийг намдаах олон бүрдэлт эмчилгээний аргын үр дүнг судлах.
24. Галбадрах, Р, Хүүхдэд үзүүлэх хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний гүнзгийрүүлсэн сургалт. 2005, Улаанбаатар.
25. Stjernsward, J. and S. Pampallona, Хөнгөвчлөх анагаах ухаан - дэлхийн чиг хандлага. 2005, Ulaanbaatar.
26. Stjernsward, J. and S. Pampallona, Palliative medicine- global perspective. 2000: WHO.
27. National Cancer control programmes: policies and managerial guidelines. Second ed. 2002, Geneva: WHO.
28. National Cancer Control Program 2007-2017. 2008, Mongolia: NCC, МОН.
29. Cancer pain relieves. Second ed. 1996, Geneva: WHO.
30. Cancer pain relieve and palliative care. 1990, Geneva: WHO.
31. Pain, Pain terms: a list with definitions and notes on usage. 1979: International Association for the study of Pain, Subcommittee on Taxonomy.
32. Pain relieve in children and palliative care, IASP: WHO.
33. Emanuel, L., et al., EPEC-O., Education in Palliative and End -of-life Care for Oncology. 2005.
34. Woodruff, R., Cancer pain. Second ed. 1999: Oxford University press.
35. Clinical Practice Guidelines in Oncology, Adult cancer pain. Second ed. 2005: NCCN.
36. Charles F.von Gunten, M.D., Ph.D., and Frank D. Ferris EPEC-O., Education in Palliative and End -of-life Care for Oncology, Pain. 2005.
37. Leon-Casasola, O.A.d., and Cancer Pain: Pharmacological, Interventional and palliative Care Approaches. 2006.
38. P.Prithvi Raj, L.L., Serdar Erdine, Peter S.Staats Radiographic Imaging for Regional Anesthesia and Pain Management. 2003.

39. Strichartz, e.R.B.M., Essentials of Pain Medicine and Regional Anesthesia. 1999.
40. Winnie, W., Interventional Pain Management. 1996.
41. Pain management and palliative care for children. 1986, Geneva: WHO.
42. Patty Wu "Patty Wu's Palliative Medicine Pocket Companion. 2008, San Diego Hospice: The Institute for Palliative Medicine.
43. When Children Die, M.J., Field and Richard E. Behrman Improving Palliative and End -of-life Care for Children and Their Families. 2002: IOM of the National Academies.
44. Ying Guo, Benedict Konzen. Lymphedema, Textbook of palliative medicine 2006. P187-197